

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2025 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2025 ОНЫ 03 ДУГААР САРЫН 20-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААН

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

*Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.*

БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2025 оны 03 дугаар сарын 20-ны өдөр, Пүрэв гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2-6
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	7-13
<hr/>	
1.Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын жагсаалтад ороогүй хууль, тогтоолын төслүүдийг чуулганаар хэлэлцүүлэх эсэх асуудал	7-10
2.Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 01 дүгээр дүгнэлт /Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн зарим хэсэг Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн эсэх/	10-14

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы
Төрийн байгуулалтын байнгын хорооны 03 дугаар сарын 20-ны өдөр
/Пүрэв гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 25 гишүүнээс 13 гишүүн хүрэлцэн ирж, 52.0 хувийн ирцтэйгээр хуралдаан 11 цаг 15 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: Д.Амарбаясгалан, Ж.Бат-Эрдэнэ, Ж.Баярмаа,
Н.Номтойбаяр, Н.Учрал;

Чөлөөтэй: С.Амарсайхан, Ө.Шижир, Л.Мөнхбаатар, Л.Оюун-Эрдэнэ,
Л.Гантөмөр, Ц.Туваан.

**Нэг.Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганаар
хэлэлцэх асуудлын жагсаалтад ороогүй хууль, тогтоолын төслүүдийг
чуулганаар хэлэлцүүлэх эсэх асуудал**

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Ц.Баянмөнх, Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд Төрийн байгуулалтын Байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох нар байлцав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7-д энэ хуулийн 5.1-д заасан жагсаалтад ороогүй хууль, тогтоолын төсөл өргөн мэдүүлснийг Зөвлөлийн саналыг харгалзан Төрийн байгуулалтын байнгын хороо хэлэлцэж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн бол чуулганаар хэлэлцүүлнэ гэж заасны дагуу өргөн мэдүүлсэн төсөл бүрээр санал хураалт явуулав.

Ц.Сандаг-Очир: 1.Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар нарын 9 гишүүнээс 2025.01.23-ны өдөр өргөн мэдүүлсэн Хууль, тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн санал хураалт явууля.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 6

Бүгд: 13

53.8 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Засгийн газраас 2025.01.23-ны өдөр өргөн мэдүүлсэн Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн санал хураалт явууля.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 6
Бүгд: 13

53.8 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Засгийн газраас 2025.01.24-ний өдөр өргөн мэдүүлсэн Хүний эрх, эрх чөлөөг хангахтай холбоотой зарим хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 5
Бүгд: 13

61.5 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Засгийн газраас 2025.01.24-ний өдөр өргөн мэдүүлсэн Жагсаал, цуглаан хийх эрх чөлөөний тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 5
Бүгд: 13

61.5 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Засгийн газраас 2025.01.24-ний өдөр өргөн мэдүүлсэн Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 4
Бүгд: 13

69.2 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Засгийн газраас 2025.03.17-ны өдөр өргөн мэдүүлсэн Гашуун сухайт-Ганц мод боомтын хил дамнасан төмөр зам, нүүрсний худалдаа Тавантолгойн нүүрсний уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлэх хамтын ажиллагааны тухай Монгол Улсын Засгийн газар болон БНХАУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийг чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 5
Бүгд: 13

61.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Э.Болормааг дэмжсэнд тооцож, 69.2 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Улсын Их Хурлын гишүүн О.Амгаланбаатараас 2025.03.17-ны өдөр өргөн мэдүүлсэн Амьтны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 3
Бүгд: 13
76.9 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин нарын 3 гишүүнээс 2025.03.17-ны өдөр өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 3
Бүгд: 13
76.9 хувийн саналаар дэмжигдлээ.

9.Улсын Их Хурлын гишүүн О.Цогтгэрэл нарын 26 гишүүнээс 2025.03.17-ны өдөр өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 4
Бүгд: 13
69.2 хувийн саналаар дэмжигдлээ.

10.Улсын Их Хурлын гишүүн Г.Уянгахишигээс 2025.03.17-ны өдөр өргөн мэдүүлсэн Өмгөөллийн тухай хуулийн зарим заалтыг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 4
Бүгд: 13
69.2 хувийн саналаар дэмжигдлээ.

11.Улсын Их Хурлын гишүүн Ч.Лодойсамбуу нарын 19 гишүүнээс 2024.12.27-ны өдөр өргөн мэдүүлсэн Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 4
Татгалзсан: 9
Бүгд: 13
30.8 хувийн саналаар дэмжигдсэнгүй

Уг асуудлыг 11 цаг 26 минутад хэлэлцэж дууслаа.

Хоёр.Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 01 дүгээр дүгнэлт /Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн зарим хэсэг Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн эсэх/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Ц.Баянмөнх, Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд Төрийн байгуулалтын Байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох нар байлцав.

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2, 31.3, 31.4 дэх хэсэг Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай цэцийн дүгнэлтийг итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир танилцуулав.

Цэцийн дүгнэлт болон итгэмжлэгдсэн төлөөлөгчтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэг үг хэлэв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 84 дүгээр зүйлийн 84.2.2-д заасны дагуу “ ... Байнгын хороод Цэцийн дүгнэлтийг хэлэлцэн санал, дүгнэлт гаргахдаа холбогдох хууль, тогтоолын Монгол Улсын Үндсэн хууль зөрчсөн гэсэн зүйл, хэсэг, заалт бүрээр, хэрэв Монгол Улсын Үндсэн хуулийн хэд хэдэн заалтыг зөрчсөн бол Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалт бүрээр тус тусад нь санал хураалт явуулах;” гэж заасны дагуу санал хураалт явуулав.

Ц.Сандаг-Очир: 1. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2 дахь хэсэгт “Бие даан нэр дэвшүүлэгч нь Сонгуулийн ерөнхий хорооноос баталсан маягтад тухайн сонгуулийн тойргийн 801-ээс доошгүй тооны сонгогчдын гарын үсгийг зуруулна” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Аравдугаар зүйлийн 3 дахь хэсэгт “Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ.” гэж заасныг зөрчсөн байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8

Татгалзсан: 6

Бүгд: 14

57.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэгийг дэмжсэнээр тооцож, 64.3 хувийн саналаар дэмжигдлээ.

2. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2 дахь хэсэгт “Бие даан нэр дэвшүүлэгч нь Сонгуулийн ерөнхий хорооноос баталсан маягтад тухайн сонгуулийн тойргийн 801-ээс доошгүй тооны сонгогчдын гарын үсгийг зуруулна” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна.” гэж заасныг зөрчсөн байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 5
Бүгд: 14

64.3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2 дахь хэсэгт “Бие даан нэр дэвшүүлэгч нь Сонгуулийн ерөнхий хорооноос баталсан маягтад тухайн сонгуулийн тойргийн 801-ээс доошгүй тооны сонгогчдын гарын үсгийг зуруулна” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Хүнийг ... үзэл бодол ...-оор нь ялгаварлан гадуурхаж үл болно.” гэж заасныг зөрчсөн байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 5
Бүгд: 14

64.3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

4. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2 дахь хэсэгт “Бие даан нэр дэвшүүлэгч нь Сонгуулийн ерөнхий хорооноос баталсан маягтад тухайн сонгуулийн тойргийн 801-ээс доошгүй тооны сонгогчдын гарын үсгийг зуруулна” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 9 дэх заалтад “ ... Төрийн байгууллагад ... сонгогдох эрхтэй. ...” гэж заасныг зөрчсөн байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 5
Бүгд: 14

64.3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 22 минут үргэлжилж, ирвэл зохих 25 гишүүнээс 14 гишүүн хүрэлцэн ирж, 56.0 хувийн ирцтэйгээр 11 цаг 37 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Ж.БАТ-ЭРДЭНЭ

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ
2025 оны 03 дугаар сарын 20-ны өдөр,
Пүрэв гараг Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар” танхим 11 цаг 15 минут

**ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

Ц.Сандаг-Очир: Эрхэм гишүүдийн өдрийн мэндийг хүргэе.

Төрийн байгуулалтын байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирж ирц бүрдсэн тул Байнгын хорооны 2025 оны 3 дугаар сарын 20-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье ээ. Өнөөдрийн байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

1.Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын жагсаалтад ороогүй хууль тогтоолын төслүүдийг чуулганаар хэлэлцүүлэх эсэх асуудлыг.

2.Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 1 дүгээр дүгнэлтийг тус тус хэлэлцэнэ ээ.

Хэлэлцэх асуудалтай саналтай гишүүн байна уу? Байхгүй байна. Хэлэлцэх асуудал батлагдлаа.

Хэлэлцэх асуудалдаа оръё.

1.Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын жагсаалтад ороогүй хууль тогтоолын төслүүдийг чуулганаар хэлэлцүүлэх эсэхийг шийдвэрлэх тухай асуудлыг хэлэлцэнэ ээ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5.7-д энэ хуулийн 5.1-д заасан жагсаалтад ороогүй хууль тогтоолын төсөл өргөн мэдүүлснийг зөвлөлийн саналыг харгалзан Төрийн байгуулалтын байнгын хороо хэлэлцэж хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн бол чуулганаар хэлэлцүүлнэ гэж заасан.

Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн төсөл бүрээр санал хураалт явуулна аа.

Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар нарын 9 гишүүнээс 2025 оны 1 сарын 23-ны өдөр өргөн мэдүүлсэн Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль тогтоолын төслүүдийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7 дахь хэсэгт заасны дагуу чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт.

Гишүүдийн 53.8 хувь нь дэмжигдлээ.

2.Засгийн газраас 2025 оны 1 сарын 23-ны өдөр өргөн мэдүүлсэн Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7 дахь хэсэгт заасны дагуу чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт.

53.8 хувиар санал дэмжигдлээ.

3.Засгийн газраас 2025 оны 1 сарын 24-ний өдөр өргөн мэдүүлсэн Хүний эрх эрх чөлөөг хангахтай холбоотой зарим хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7 дахь хэсэгт заасны дагуу чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт.

Санал хураалт.

Санал хураалт 61.5 хувиар дэмжигдлээ.

4.Засгийн газраас 2025 оны 1 сарын 24-ний өдөр өргөн мэдүүлсэн Жагсаал цуглаан хийх эрх чөлөөний тухай хууль шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7 дахь хэсэгт заасны дагуу чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт.

Хуралдаанд оролцсон гишүүдийн 61.5 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Засгийн газраас 2025 оны 1 сарын 24-ний өдөр өргөн мэдүүлсэн Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7 дахь хэсэгт заасны дагуу чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт.

Санал хураалт 69.2 хувиар дэмжигдлээ.

6.Засгийн газраас 2025 оны 3 сарын 17-ны өдөр өргөн мэдүүлсэн Гашуун сухайт-Ганц мод боомтын хил дамнасан төмөр зам, нүүрсний худалдаа Тавантолгойн нүүрсний уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлэх хамтын ажиллагааны тухай Монгол Улсын Засгийн газар болон БНХАУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төсөл. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7 дахь хэсэгт заасны дагуу чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт.

61.5 хувиар санал дэмжигдлээ.

Болормаа гишүүнийг дэмжсэнд тооцоорой.

7.Улсын Их Хурлын гишүүн О.Амгаланбаатараас 2025 оны 3 сарын 17-ны өдөр өргөн мэдүүлсэн Амьтны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7 дахь хэсэгт заасны дагуу чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт.

Санал хураалт 76.9 хувиар дэмжигдлээ.

8.Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин нарын 3 гишүүнээс 2025 оны 3 сарын 17-ны өдөр өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт. өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7 дахь хэсэгт заасны дагуу чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт.

76.9 хувиар санал дэмжигдлээ.

9.Улсын Их Хурлын гишүүн О.Цогтгэрэл нарын 26 гишүүнээс 2025 оны 3 сарын 17-ны өдөр өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7 дахь хэсэгт заасны дагуу чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт.

Санал хураалт 69.2 хувиар дэмжигдлээ.

10.Улсын Их Хурлын гишүүн Г.Уянгахишигээс 2025 оны 3 сарын 17-ны өдөр өргөн мэдүүлсэн Өмгөөллийн тухай хуулийн зарим заалтыг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7 дахь хэсэгт заасны дагуу чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт.

69.2 хувиар санал дэмжигдлээ.

11.Улсын Их Хурлын гишүүн Ч.Лодойсамбуу нарын 19 гишүүнээс энэ хуулийн төсөл бол намрын чуулганы хэлэлцэх асуудлын төлөвлөгөөнд оруулъя гээд бас

дэмжигдээгүй хуулийн төсөл юм байна шүү. Лодойсамбуу нарын 19 гишүүнээс 2024 оны 12 сарын 27-ны өдөр өргөн мэдүүлсэн Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7 дахь хэсэгт заасны дагуу чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт.

Санал хураалт 30.8 хувиар дэмжигдсэнгүй.

Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын жагсаалтад ороогүй хууль, тогтоолын төслүүдийг чуулганаар хэлэлцүүлэх эсэх шийдвэрлэх тухай асуудлыг хэлэлцэн шийдвэрлэлээ.

11.26 цагт

Дараагийн 2 дахь асуудалдаа оръё.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 1 дүгээр дүгнэлтийг хэлэлцэнэ ээ.

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2, 31.3, 31.4 дэх хэсэг Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай цэцийн дүгнэлтийг бас танилцуулна аа.

Байнгын хорооны гишүүд ээ,

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцэд нэр бүхий иргэнээс Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2, 31.3, 31.4 дэх хэсэг Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн талаар өргөдөл гомдол гаргасны дагуу Үндсэн хуулийн цэц 2025 оны 1 дүгээр сарын 15-ны өдрийн дунд суудлын хуралдаанаар уг маргааныг хянан хэлэлцсэн бөгөөд миний бие уг маргаанд Монгол Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр томилогдож оролцсон болно.

Үндсэн хуулийн цэцэд ирүүлсэн иргэний өргөдөл гомдлын агуулга нь Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2 дахь хэсэгт бие даан нэр дэвшүүлэгч нь СЕХ-оос баталсан маягтад тухайн сонгуулийн тойргийн 801-ээс доошгүй тооны сонгогчдын гарын үсгийг зуруулна гэсэн алдаатай гэж үзээд энэхүү дэвшүүлэгч үйлийн эзэн нь бусад сонгогчдоосоо 801-ээс доошгүй гарын үсэг зуруулах шаардлагатай мэтээр заасан нь нэг мөр ойлгох боломжгүй. Үйлийн эзнийг буюу биеийн төлөөний үгээ буруу тодорхойлсон монгол хэлний найруулга зүйн алдаатай, иргэд Үндсэн хуулиар хамгаалагдсан баталгаажуулсан эрхээ эдлэх гэж заавал 801-ээс доошгүй иргэний гарын үсэг цуглуулах ёстой байхад намын гишүүд дээрх гарын үсгийг цуглуулахгүй намын сонголтгоор шууд нэр дэвших эрхээ эдэлж байгаа нь тэгш эрхийн зарчимд нийцэхгүй байна аа. Нам бол ТББ. Бид бүгд Монгол Улсын иргэний хувьд ижилхэн эрхтэй. Тэд Үндсэн хуульд заасан дээрх эрхээ шууд эдэлж байхад иргэн яагаад уг эрхээ эдлэх боломжгүй ялгаварлагдан гарын үсэг цуглуулах үүрэгтэй нь ойлгомжгүй.

Монгол Улсын Үндсэн хуулийн 17 дугаар зүйлд заасан үүргүүдэд энэ тухай огт заагаагүй. Иймээс Монгол Улсын үндсэн хуулийн 14 дүгээр зүйлийн нэг дэх хэсэгт Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль шүүхийн өмнө эрх тэгш байна, 2 дахь хэсэгт Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгэм, эмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно. Хүн бүр эрх зүйн этгээд байна.

16 дугаар зүйлийн 9 дэх заалтад Төрийн байгууллагад сонгогдох эрхтэй гэснийг зөрчиж байгаа учир Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2 дахь хэсгийн үйлчлэлийг яаралтай хүчингүй болгож өгнө үү гэсэн байна.

Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч миний бие Үндсэн хуулийн цэцэд Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2, 31.3, 31.4 дэх хэсэг нь Монгол Улсын үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчөөгүй талаарх тайлбараа хүргүүлэн гаргаж ажилласан.

Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдааны явцад өргөдөл гаргагч иргэн Д.Алтангэрэл Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3, 31.4 дэх хэсэг, Монгол Улсын үндсэн хуулийн 10 дугаар зүйлийн 3, 14 дүгээр зүйлийн 1, 2 дахь хэсэг, 16 дугаар зүйлийн 9 дэх заалт, 19 дүгээр зүйлийн 1, 70 дугаар зүйлийн нэг дэх хэсгийг мөн маргаан үүсгэсэн тус хуулийн 31 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын Үндсэн хуулийн 10 дугаар зүйлийн 3, 19 дүгээр зүйлийн 1, 70 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн холбогдох заалтыг зөрчсөн эсэхийг тогтоолгохоор өргөдлийн шаардлагаа нэмэгдүүлж тайлбар хийсэн болно.

Үндсэн хуулийн цэц уг маргааныг дунд суудлын хуралдаанаараа хянан хэлэлцээд Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2 дахь хэсэгт бие даан нэр дэвшүүлэгч нь СЕХ-оос баталсан маягтад тухайн сонгуулийн тойргийн 801-ээс доошгүй тооны сонгогчдын гарын үсгийг зуруулна гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн 10 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ, 14 дүгээр зүйлийн нэг дэх хэсэгт Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль шүүхийн өмнө эрх тэгш байна, 2 дахь хэсэгт хүнийг үзэл бодлоор нь ялгаварлан гадуурхаж үл болно, 10 дугаар зүйлийн 9 дэх заалтад төрийн байгууллагад сонгогдох эрхтэй гэснийг тус тус зөрчсөн байна гэсэн дүгнэлтийг гаргасан байна аа.

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг бүрэн эхээр нь та бүхэнд тараасан байгаа тул асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү.

Цэцийн дүгнэлтийг та бүхэнд танилцууллаа.

Цэцийн дүгнэлттэй холбогдуулж дүгнэлтээс, итгэмжилсэн төлөөлөгчөөс асуух асуулттай гишүүн байна уу? Нэрсээ өгнө үү? Алга байна алга уу? Номинчимэг гишүүнээр тасаллаа. Номинчимэг гишүүн.

О.Номинчимэг: Бүгдээрэнд нь өдрийн мэнд хүргэе.

Хууль зүйн байнгын хороогоор энэ асуудал орсон. Ер нь дэмжигдсэн байгаа. Тэгээд зарчмын хувьд энд бол гарын үсэг цуглуулах нь бол Үндсэн хууль зөрчөөгүй. Энэ байх ёстой шалгуур. Зөвхөн тооны хувьд бид нар харж үзэх ёстой шүү гэсэн гол дүгнэлт байгаа учраас үүнийг аваад сонгуулийн хууль дээрээ бас илүү боловсронгуй болгох тал дээр ажиллах нь зүйтэй гэж үзэж байгаа.

Зүгээр өнөөдөр энэ дээр нөгөө хэлэх гэж байгаа юм маань бид нар ер нь Цэцдээ Улсын Их Хурал энэ цэцийн маргаан дээр яаж оролцох вэ гэдэг тал дээр бас анхаарч үзэж энэ дээрээ бас сайжруулах зүйл байна гэж харж байгаа. Бид нарын хувьд бас ингээд нэг чуулган яваад үзчихлээ.

Миний хувьд ч гэсэн цэц дээр Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч болоод ажиллаж үзэж байна. Ер нь бид нар ингээд урьд нь баталсан хуулиа Улсын Их Хурлын гишүүн итгэмжилсэн төлөөлөгч болоод цэцийн өмнө хамгаалах энэ мэтгэлцээнд ороход ерөөсөө нэг дүгнэлт бичээд хариу бичээд Тамгын газраас өгчихдөг. Өөрөө ингээд аваад яваад яв гээд ингээд өөр мэргэжил арга зүйн зөвлөгөө яг цэц дээр очоод мэтгэлцээнд ороод асуулт хариултад ингээд яахад Тамгын газраас бас энэ дээр яг мэргэжлийн арга зүйгээр зөвлөдөг хүмүүс маань хамтдаа ажилладаг байхгүй бол яг үнэнийг хэлэхэд тэгээд нөгөө гишүүд маань нэг юмаа уншаад оччихдог. Хааяа бас ингээд Цэцийн та бүхэн харж байгаа бол манай цэцийн энэ дүгнэлтүүд шийдвэрүүд нэлээн үндэслэлтэй, суурьтай аягүй өргөн хүрээний ийм хэлэлцүүлгүүдийг хийж асуулт хариулт мэтгэлцээнүүдийг хийж энэ шийдвэрээ гаргадаг болсон. Тэгэхээр энэ болгонд өөрөө бэлддэг энэ нэг жоохон системтэй Тамгын газрын өөрийнх нь бас нэг арга зүйн ийм зөвлөгөө өгдөг ийм системийг бий болгохгүй бол одоо үнэндээ бол нэг гишүүн очоод л өөрийнхөөрөө нэг ярьчаад л ирж байгаа асуудал байгаад байгаа.

Тэгэхээр хаа хаанаа бид нар өөрсдөө энэ мэтгэлцээний хууль эрх зүйн асуудлаа илүү өндөр түвшинд авч явах энийгээ олон нийтэд бас зөв хүргэхийн тулд энэ дээрээ бас нэг анхаарах ёстой болов уу. Энэ дээр бас манай илүү эрхэлсэн Төрийн байгуулалтын байнгын хороо, Улсын Их Хурлын тамгын газартай ярилцаад цэцэд Улсын Их Хурлын гишүүн итгэмжилсэн төлөөлөгчөөр ажиллах тохиолдолд яаж мэргэжил арга зүйн тусам дэмжлэг үзүүлэх вэ гэдэг дээрээ 1 нэгдсэн шийдэлд хүрсэн нь дээр байх гэсэн ийм саналтай байгаагаа хэлж байгаа юм. Баярлалаа.

Ц.Сандаг-Очир: Номинчимэг гишүүн үг хэллээ тийм ээ.

Гишүүд асуулт асууж үг хэлж дууслаа.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 84.2.2-т заасны дагуу Байнгын хороод цэцийн дүгнэлтийг хэлэлцэн санал, дүгнэлт гаргахдаа холбогдох хууль, тогтоолын Монгол Улсын Үндсэн хууль зөрчсөн гэсэн зүйл хэсэг заалт бүрээр, хэрэв Монгол Улсын Үндсэн хуулийн хэд хэдэн заалтыг зөрчсөн бол Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалт бүрээр тус тусад нь санал хураалт явуулна гэж заасан.

Санал хураалт явуулъя.

1.Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2 дахь хэсэгт бие даан нэр дэвшигч нь СЕХ-оос баталсан маягтад тухайн сонгуулийн

тойргийн 801-ээс доошгүй тооны сонгогчдын гарын үсгийг зуруулна гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн 10 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт Монгол Улсын олон улсын гэрээнд соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль, тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ гэж заасныг зөрчсөн байна гэснийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт.

57.1 хувиар санал дэмжигдлээ.

Номинчимэг гишүүнийг дэмжсэнд тооцоорой.

2.Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2 дахь хэсэгт бие даан нэр дэвшүүлэгч нь сонгуулийн ерөнхий хорооноос баталсан маягтад тухайн сонгуулийн тойргийн 801-ээс доошгүй тооны сонгогчдын гарын үсгийг зуруулна гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн 14 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль шүүхийн өмнө эрх тэгш байна гэж заасныг зөрчсөн байна гэснийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт.

64.3 хувиар санал дэмжигдлээ.

3.Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2 дахь хэсэгт бие даан нэр дэвшигч нь сонгуулийн ерөнхий хорооноос баталсан маягтад тухайн сонгуулийн тойргийн 801-ээс доошгүй тооны сонгогчдын гарын үсэг зуруулна гэж заасан нь Монгол Улсын үндсэн хуулийн 14 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт хүнийг үзэл бодлоор нь ялгаварлан гадуурхаж үл болно гэж заасныг зөрчсөн байна гэснийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн томьёоллоор гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт.

64.3 хувиар санал дэмжигдлээ.

Сүүлчийн санал хураалт.

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2 дахь хэсэгт бие даан нэр дэвшигч нь СЕХ-оос баталсан маягтад тухайн сонгуулийн тойргийн 801-ээс доошгүй тооны сонгогчдын гарын үсэг зуруулна гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 9 дэх заалтад төрийн байгууллагад сонгогдох эрхтэй гэж заасныг зөрчсөн байна гэснийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт.

64.3 хувиар санал дэмжигдлээ.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 1 дүгээр дүгнэлтийг хэлэлцэж дууслаа.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 1 дүгээр дүгнэлтийг хэлэлцсэн талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн хэн танилцуулах вэ? Би танилцуулж болох уу? Би чинь өөрөө итгэмжлэн төлөөлөгч болох уу? Миний бие танилцуулна.

ТББХ-ны хэлэлцэх асуудал дууссан тул өнөөдрийн хуралдааныг хаасныг мэдэгдье. Чуулганы хуралдаандаа идэвхтэй оролцсон гишүүдэд баярлалаа.

11.37 цагт

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ, ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА